

2024-2025

МИЦУБИШИ АЗИЙН ХҮҮХДИЙН ЭНИКИ ФЕСТИВАЛЬ


Чамайг өдрийн тэмдэглэл бүхий зураг “ЭНИКИ”-гээ ирүүлэхийг урьж байна.

Чи өөрийнхөө өдөр тутмын амьдралыг Азийн бусад орны хүүхдүүдэд танилцуулна уу. Өдрийн тэмдэглэл бүхий зургуудаараа өөрийгөө илэрхийлээрэй.

Энэхүү зургийн уралдаан нь Азийн хүүхдүүд өдрийн тэмдэглэл /эссэ/ бүхий өөрсдийн зурсан зургаар дэлхийн өргөн олон хүүхдүүдтэй танилцах ховорхон завшааныг тэдэнд бэлэглэдэг. Бид соёлын гайхамшигт олон төрөлтэй Азийн 24 орны хүүхдүүдийг “Ази тивийн бүх ард түмэнтэй хуваалцахыг хүсэж буй миний амьдрал” хэмээх чөлөөт сэдэвт өдрийн тэмдэглэл бүхий зургуудаа ирүүлэхийг урьж байна. Хүүхдүүд та нар амьдралынхаа 3 өдрийг дүрслэн зурж, тус бүрд нь тэмдэглэл хийгээд өөрийн амьдралын аз жаргалтай мөчүүдээ Азийн найз, анд нөхөдтэйгөө хуваалцаарай.

Оролцогчдод тавих шаардлага

- Хэлбэр** Оролцогч нь бүтээлээ 3 хуудсанд багтаасан байна. Хуудас бүр чиний нэг өдрийн амьдралаас сэдэвлэсэн зураг, мөн богино эссэтэй байна /өнгийн харандаа, тос, усан будаг ашиглана/.
- Хэмжээ** А4 хэмжээтэй (297 мм X 210 мм) цаасны дээд хэсэг (талбайн гуравны хоёр)-т зураг зурж, доод хэсэг (талбайн гуравны нэг)-т зургийн тайлбар бүхий эссэ бичнэ. Зургийн цаасны ар талыг цэвэр хэвээр үлдээнэ.
- Насны хязгаар** 6-12 настай хүүхдүүд оролцоно.
- Сэдэв** “Ази тивийн бүх ард түмэнтэй хуваалцахыг хүсэж буй миний амьдрал”. Өдөр тутмын амьдралынхаа юуг ч дүрслэж болно. Жишээ нь: Гэр бүл, анд нөхөд, сургууль, ёс заншил, баяр наадам, хүмүүсийн амьдрал гэх мэт.
- Бүтээл ирүүлэх хугацаа** 2024 оны 7 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 30-ныг дуустал



Шалгаруулалтыг мэдээлэх

Олон улсын шалгаруулалтын дүнг 2025 оны 5 дугаар сард мэдээлнэ.

Олгох шагналууд

Гран-При [Улс бүрээс 1 ялагч] * Гран-При шагнал хүртсэн ялагч нь Япон улсад аялж шагнал гардуулах ёслолын арга хэмжээнд оролцоно.
Мицубишигийн олон нийттэй харилцах хороо [Улс бүрээс 1 ялагч]
Ази-Номхон далайн бүсийн ЮНЕСКО-ийн Клуб, Нийгэмлэгүүдийн Холбоо [Улс бүрээс 1 ялагч]
ЮНЕСКО-ийн Клуб, Нийгэмлэгүүдийн Японы Үндэсний Холбоо [Улс бүрээс 1 ялагч]
Тусгай байрын шагнал [Улс бүрээс 4 ялагч]
*Зургийн уралдааны удирдамжийг www.enikkimongolia.mn хаягаар орж татаж авна уу.
*Оролцогч хүүхэд багачууд та бүхэн бүтээлээ доорх хаягаар ирүүлээрэй!
(Гэр, сургуулийн хаяг, холбогдох утас, нас хүйс зэргийг үнэн зөв бичиж ирүүлнэ)
*Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Ривер Вилла, 8/1 дүгээр байр, 5-р давхарт 57 тоот, Байгаль, соёлын өвийг хамгаалах сан
Харилцах утас: 99122722, 80988094



Оролцогч улс орнууд: Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бутаны Хаант Улс, Бруней Даруссалам Улс, Камбожийн Вант Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Индонез Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Малайз Улс, Мальдивын Бүгд Найрамдах Улс, Монгол Улс, Бүгд Найрамдах Мьянмарын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс, Исламын Бүгд Найрамдах Пакистан Улс, Бүгд Найрамдах Филиппин Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Ардчилсан Социалист Бүгд Найрамдах Шри Ланка Улс, Хятадын Тайпей - Тайван Улс, Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Тимор Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Япон Улс.

Зохион байгуулагчид: Мицубишигийн Олон нийттэй Харилцах Хороо / Ази-Номхон далайн бүсийн ЮНЕСКО-ийн Клуб, Нийгэмлэгүүдийн Холбоо / ЮНЕСКО-ийн Клуб, Нийгэмлэгүүдийн Японы Үндэсний Холбоо
Үндэсний хэмжээнд зохион байгуулагч: ЮНЕСКО-ийн Батламжит ТББ - Байгаль, соёлын өвийг хамгаалах сан.

Мицубиши корпорац “Мицубиши Азийн Хүүхдийн Эники Фестиваль”-ийг ивээн тэтгэв.